Монгол уламжлалт анагаах ухааны эх сурвалжууд дахь хятад анагаах ухааны эмчилгээний арга туршлагын зарим нөлөөлөл

Г.Цэцэнбаатар[1], Ч.Чимэдрагчаа[2], Н.Батсайхан[1,3], Т.Алимаа[1,3]

[1]АШУҮИС. МАУОУС, Монгол Анагаах Ухаан Судлалын тэнхим
[2]Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэн
[3]АШУҮИС. Монгол Уламжлалт Анагаах Ухааны Хүрээлэн
Цахим шуудан: alimaa.t@mnums.edu.mn, Утас: 99040103

Түлхүүр үг:
Сурвалж судлал
Агууламжийн судалгаа
Кодлон судлах
Сэдвээр бүлэглэх

Товч утга:
Үндэслэл: Дэлхий дахинаа өнөөг хүртэл хэрэглэгдэж ирсэн, өвөрмөц онцлог агуулсан, эмнэн засах арга бүхий эмнэлгүүд болон европ анагаах ухааны эмчилгээ, үйлчилгээ нь өнөөгийн олон улс орны эрүүл мэндийн үйлчилгээнд хосолмол хэлбэрээр хэрэглэгдэж буй бөгөөд тэдгээрийг нэгдмэлжүүлэн нэгтгэх боломж бололцооны асуудал судлаачдын дунд өргөн хэлцэгддэг асуудлын нэг ажээ. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжилд Хятад болон бусад эмнэлгүүдийн нөлөөлөл хэрхэн тусгагдсан талаар нарийвчлан дүн шинжилгээ хийсэн, бие даасан судалгааны ажлын үр дүн өнөөг хүртэл хэвлэгдээгүй байгаа тул энэ асуудлыг чиглэл бүрээр тус бүрчлэн задлан шинжилж судлах нь өнөөгийн Монголын уламжлалт анагаах ухаан хэрхэн бүрэлдэн бий болсон түүхэн явцыг тодруулахад чухал шаардлагатай хэмээн үзэж байна. **Зорилго:** Монгол эмч нарын бүтээлүүдэд тодорхой кодуудын хүрээнд судалгаа явуулж хятад анагаах ухааны өгөгдөл, мэдлэг, мэдээлэл байгааг илрүүлэх. **Арга, аргачлал:** Судалгааны ажлыг түүх, эх сурвалж зохиолуудад тулгуурлан чанарын судалгааны аргаар явуулав. Судалгааны ажлын хэрэглэгдэхүүнүүдэд эх бичгийг кодлон судлах, сэдвээр бүлэглэх болон агууламжийн судалгааны аргуудын дагуу уг ажлыг гүйцэтгэв. **Үр дүн:** Кодлох судалгааны үр дүнгээс үзэхэд хятад эмнэлгээс авч хэрэглэсэн мэдээллүүдийн ихэнх нь “Халдвар” гэсэн кодод хамрагдаж байгаа болох нь илэрч байна. Үүнийг тус бүрчлэн авч үзвэл Сүмбэ Хамба Ишбалжирын бүтээлд уг мэдээллийн 42.8%, Цахар Гэвш Лувсанчүлтэмийн номд 50%, Миндол Хутагт Жамбалчойжиданзанпэрэнлэйн зохиолд 47.05%, Ишданзанванжил зохиосон “Шүрэн Чимэг”–т 87.5% нь халдвар гэсэн кодод хамарч байсан. Үүний дараагаар “Бэртэл гэмтэл” гэсэн кодод хамрагдах мэдээллийг зохиол тус бүрээр ангилан ялгахад Ишбалжирын бүтээлд 33.3%, Лувсанчүлтэмийн бүтээлд 0%, Миндол Хутагт Жамбалчойжиданзанпэрэнлэйн бүтээлд 24,0%, Ишданзанванжилын бүтээлд 6.25% гарч байгаа нь нийт кодуудын дотор удаах байранд орж байна. **Дүгнэлт:** 1.Судалгааны үр дүнгээс харахад дээрх бүтээлүүдэд хятад эмнэлгийн мэдээллүүдийн 56.66% нь халдварын тохиолдолтой холбоо бүхий мэдээллүүд байна. 2.Бодоо зэрэг халдварт өвчний үед хятад анагаах ухаанаас суралцсанаа монгол уламжлалт анагаах ухааны арга аргачлалтай ижилсүүлэн нэгтгэсэн нь өнөө үеийн нэгтгэмэл анагаах ухааны үйл явцыг нөхцөлдүүлсэн нэгэн томоохон нөлөөлөх хүчин зүйлийн илэрц байж болзошгүй.

Үндэслэл: Дэлхий дахинаа өнөөг хүртэл хэрэглэгдэж ирсэн, өвөрмөц онцлог агуулсан, эмнэн засах арга бүхий эмнэлгүүд болон европ анагаах ухааны эмчилгээ, үйлчилгээ нь өнөөгийн олон улс орны эрүүл мэндийн үйлчилгээнд хосолмол хэлбэрээр хэрэглэгдэж буй бөгөөд тэдгээрийг нэгдмэлжүүлэн

нэгтгэх боломж бололцооны асуудал судлаачдын дунд өргөн хэлцэгддэг асуудлын нэг ажээ. Тухайлбал, нэгтгэмэл анагаах ухаан бүрэлдэн буй болж буй үйл явц нь зайлшгүй болохыг судлаач Б.Дагвацэрэн (2015) дурдаад “Онол арга зүйн хувьд оновчтой шийдэлд хүрээгүй” болохыг тэмдэглэсэн байдаг.[1]

Өнөө цагийн монгол уламжлалт анагаах ухаан өөрийн өнгө төрхөө олон хөгжихөд Монголчуудын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлтүүд, мөн тухайн цаг үед өрнөж байсан олон улсын улс төр, эдийн засгийн харилцааны асуудлууд голлох хүчин зүйл болж байсан болохыг судлаачид бичих болжээ. Тухайлбал, Монгол, Төвөдийн анагаах ухааны хөгжил нь хөрш зэргэлдээ орших үндэстнүүдтэй харьцах нийгэм, соёл, эдийн засгийн ээдрээ дунд явагдсан болохыг судлаач Жэйнэс нар (2008) бичиж байв.[2]

Энэхүү хөгжлийн явцыг судлаач Н.Батсайхан (2021) Монгол үндэстний туулж өнгөрүүлсэн зарим түүхэн үйл явдлуудтай холбон тодорхой жишээнүүдээр судлаад, Монголчуудын өнө урт хугацаанд хуримтлуулсан тэжээхүй ухааны мэдлэг дээр суурилан төвөд эмнэлгийн онол, дадлагаар баяжуулагдан, өөр бусад анагаах ухааны эмчилгээний туршлагыг шингээн авсан нь “Монголын уламжлалт анагаах ухаан гэж омог бардам хэлэхүйц” төвшинд хүрсэн болохыг онцлон тэмдэглэсэн байна.[3]

Хятад анагаах ухаанаас Монголын уламжлалт анагаах ухаанд орж ирсэн нөлөөллийн талаарх судалгааны ажлууд өнөөгийн байдлаар цөөвтөр хэвлэгджээ. Хэдий тийм боловч уг эмнэлгийн холбогдол бүхий зарим эх сурвалжийн зарим нэрсийг Ш.Болд нар гаргасан байна. “Монгол туургатны алдарт эмч, маарамба, мэргэдийн намтар” номын төгсгөл дэх монгол эмч, маарамба, мэргэдийн орчуулсан номын жагсаалтад (1999)-д ойролцоогоор 12-13 орчим нь хятад эх сурвалжаас орчуулагдсан бололтой, нийт дөчин тооны номын нэрс бүртгэжээ. Энэхүү бүртгэлээс үзэхэд зарим эм, эмчилгээний арга ажилбарын орчуулгын зэрэгцээ тухайн үед хятад пүүсүүдийн худалдаалж байсан эмийн нэрсийн жагсаалт ч байна.[4] Судлаач Б.Жигмэд (2009) бичихдээ зохиогч болон бичигдсэн он нь тодорхойгүй байгаа монгол жижиг зохиолууд цөөнгүй байгаа бөгөөд тэдний дотор монгол эртний уламжлалт анагаах арга болон хятад эмнэлгийн туршлагууд тааралдаж байгааг дурджээ.[5]

Хэдий тийм боловч Монголын уламжлалт анагаах ухааны хөгжилд Хятад болон бусад эмнэлгүүдийн нөлөөлөл хэрхэн тусгагдсан талаар нарийвчлан дүн шинжилгээ хийсэн, бие даасан судалгааны ажлын үр дүн өнөөг хүртэл хэвлэгдээгүй байгаа нь анхаарууштай асуудал юм. Энэ асуудлыг чиглэл бүрээр тус бүрчлэн задлан шинжлэх нь өнөөгийн Монголын уламжлалт анагаах ухаан хэрхэн бүрэлдэн бий болсон түүхэн явцыг тодруулахад чухал шаардлагатай хэмээн үзэж байна. Тиймээс бид дээр дурдсан учир шалтгаанууд, чиг хандлагыг харгалзан, хятад анагаах ухаанаас дамжин орж ирсэн эм, эмчилгээний арга, ажиллагаануудыг түүхэн нөхцөл байдалтай нь холбон тодруулах нь Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийн үйл явцыг судлахад үр дүнтэй чиглэл байж болох юм гэж үзлээ.

Зорилго: Монгол эмч нарын бүтээлүүдэд тодорхой кодуудын хүрээнд судлан хятад анагаах ухааны өгөгдөл, мэдлэг, мэдээлэл байгааг илрүүлэх

Арга, аргачлал: Судалгааны ажлыг түүх, эх сурвалж зохиолуудад тулгуурлан чанарын судалгааны аргаар явуулав. Судалгааны ажлыг АШУҮИС-ийн МАУОУС, МУАУХ, УАУТХ-ийн Эрдэм шинжилгээний төвийг түшиглэн 2024 оны 6 сараас 2025 оны 2 сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүнээр Сүмбэ Хамба Ишбалжирын Рашааны Цагаан Шүүдэр (ཡེ་ཤེས་དཔལ་འབྱོར། 1994. གསོ་རིག་གསུང་རྩོམ་ཡིག་བསྡིགས། ཤྲཱ་སྭ། མི་རིགས་དཔེ་སྐྲུན་ཁང་།)[6], Цахар Гэвш Лувсанчүлтэм (1740-1810)-ийн 1802 онд бард гарсан “Басамын Тосон Эм ба Таван Рашааны Дэвтээлэг Тэргүүтэнг Найруулах Арга” (སློབ་བསང་ཚུལ་འཆི། 1802. འབའ་ཞན་སྨན་མན་ཚར་དང་འབྲེད་རྩི་ལྟ་ཁྲན་སོགས་ཏུར་ཚུལ་བཞུགས་སོ།. Модон барын хэвлэл. Цахар: Цагаан уулын сүм.)[7], Миндол Номон Хан Жамбалчойжиданзанпэрэнлэй (1789-1839)-ийн 1830 оны орчим бичсэн “Увдис Гарахын Орон”. (འཕགས་དཔལ་ཆོས་ཀྱི་བསྟན་འཛིན་འཕེན་པས། 2007. མན་ངག་རིན་ཆེན་འབྱུང་གནས། ལེ་ཧོན། མི་རིགས་དཔེ་སྐྲུན་ཁང་།)[8], Ишданзанванжилын туурвисан “Шүрэн чимэг”[9] зохиолуудыг сонгон авч, эх бичгийг кодлон судлах, сэдвээр бүлэглэх болон агууламжийн судалгааны аргуудын дагуу уг ажлыг гүйцэтгэв.[10-14]

Судалгааны ажлын үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ судалгаанд авсан эх сурвалжаас холбогдох баримтуудыг түүвэрлэн авч, мэдээ, материалыг кодлон түүвэрлэж текст хэлбэрээр бичиж оруулсан. Цуглуулсан мэдээллийг бичмэл хэлбэрт буулгасны дараа судалгааны зорилтын дагуу категорид хуваасан. Мэдээллийг зорилтот бүлэг бүрээр нэгтгэн, агуулга утга санаа, ижил төстэй санаа, агуулгын харилцан хамаарал зэргээр дугаарлан нэг дараалалд оруулав. Мөн агууламжийн судалгаагаар кодуудаа нэгтгэн тоон үзүүлэлтэд хувиргав.


Үр дүн: Сүмбэ Хамба Ишбалжирын “Рашааны Цагаан Шүүдэр” бүтээл дэх “Хятад эмнэлгийн ёсонд”, “Хятад эмчээс суралцсан”, “Хятад эмийн нэр” гэх мэтээр тодорхойлсон хэсгүүдэд дүн шинжилгээ хийхэд нийт 21 төрлийн эмгэгийн үед хятад анагаах ухааны эмчилгээний арга туршлага, мэдлэгийг ашигласан байна. Дээрх 21 төрлийн эмгэгээс хамгийн олон буюу 9 (42.8%) тохиолдол бодоо, тэмбүү, яр шарх зэрэг нь орчин үеийн анагаах ухааны ойлголтоор өвчин үүсгэгч бичил биетнээр үүсгэгдэх эмгэгүүд болох тул халдвар гэсэн нийтлэг тодорхойлолтын доор, 5 (23.8%) нь бэртэл гэмтэл, үлдсэн 7 (33.3%) тохиолдол нь бусад эмгэгүүд байна. Үүний зэрэгцээ дээрх 21 төрлийн эмгэгийн мэдээлэлд өвчин үүсэх нөхцөл, өвчний ангилал, өвчний шинж тэмдэг, оношилгоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, идээ, явдал мөр, эдгэрсэн шинж гэсэн найман төрлийн кодоор түүвэрлэн ялгахад давхардсан тоогоор нийт 33 тохиолдол илэрлээ.

Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Басамын Тосон Эм болон Таван Рашааны Дэвтээлэг Тэргүүтэнг Найруулах Ёс” бүтээлд нарийвчлан бичиж, тус бүрийг хэрхэн эмнэх эмийг бэлтгэх аргыг тайлбарласан

“Чичрэх өвчнийг эмнэх арга”, “Тэмбүү өвчнийг эмнэх арга”, “Зарим өөр эмүүд бэлдэх арга”, “Тэнгэрийн цагаан цэцгийн шүтээн хураах үрэл буюу үүсгэх долоо үрэл бэлтгэх” зэрэг эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн аргууд нь тухайн үеийн хятад эмнэлэгт өргөн хэрэглэгдэж байв. Тиймээс энэ хэсгийг нарийвчлан кодлон задлан шинжилгээ хийхэд уг бүтээлд хятад эмнэлэгтэй холбоо бүхий нийт 6 төрлийн мэдээлэл байхаас 3 (50%) нь халдварт өвчин, үлдсэн нь бусад төрлийн эмгэгүүдтэй холбоо бүхий байв. Эдгээр зургаан төрлийн эмгэгийг өвчин үүсэх нөхцөл (1), өвчний шинж тэмдэг (2), урьдчилан сэргийлэлт (1), эмчилгээ (5), эмийн нэр (2), гоо сайхан (1) халдвар хамгаалал (2) гэсэн долоон төрлийн кодоор ялган ангилахад давхардсан тоогоор 14 тохиолдол бүртгэгдэв. Эдгээрээс 9 (64.3%) нь халдвараар үүсгэгдэх бодоо, тэмбүү, чичрэг гэсэн өвчнүүдтэй холбоо бүхий кодуудад үлдсэн 5 (35.7%) нь бусад ангилалд багтаж байна.

Жамбалчойжиданзанпэрэнлэйн “Увдисын Далай” бүтээлд хятад эмнэлгийн мэдээлэл бүхий хэсгүүдэд нийт 17 төрлийн эмгэгийн үед уг анагаах ухааны арга туршлагуудыг хэрэглэхийг заажээ. Эдгээр 17 тохиолдлын хамгийн олон буюу 8 (47.05%) тохиолдол халдвар гэсэн нийтлэг тодорхойлолтын доор, 4 (24%) нь бэртэл гэмтэл, 5 (29.4%) нь бусад өвчин буюу нүдний өвчин, шүдний өвчин, бахуу өвчин, доод биеийн хүйтэн, тамир барагдсан өвчин, хөрөнгө цувирах гэсэн тодорхойлолтод багтаж байна. Эдгээр 17 эмгэгийг өвчний шинж тэмдэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт гэсэн дөрвөн төрлийн кодод давхардсан тоогоор нийт 18 тохиолдол илэрснээс эмчилгээ 15, шинж тэмдэг 2, урьдчилан сэргийлэлт тус бүр 1 байна. Ишданзанванжилын “Шүрэн чимэг” бүтээлд давхардсан тоогоор хятад анагаах ухааны мэдээлэл бүхий нийт 16 төрлийн эмгэг бүртгэгдсэнээс нүдний өвчин 1 (6.25%) ба бэртэл гэмтэл 1 (6.25%), халдвар 14 (87.5%) байлаа. Эдгээр 16 эмгэгийг өвчин үүсэх шалтгаан нөхцөл (2), өвчний шинж тэмдэг (2), засал (1), эмчилгээ (16) кодоор ангилахад нийт 21 тохиолдол байна.


Сэдвээр бүлэглэх судалгааны үр дүнгээс харахад бидний судалгаанд хэрэглэгдэхүүнээр сонгон авсан дээрх дөрвөн бүтээлд тохиолдох нийт эмгэгүүдийг нэгтгэн халдвар, бэртэл гэмтэл болон бусад гэсэн гурван сэдэвт нэгтгэн үр дүнг зохиогч тус бүрээр харуулав (Зураг 1).



Зураг 1. Сурвалж зохиолуудад бичигдсэн эмгэгүүдийн эзлэх хувь (зохиогч тус бүрээр)

Эндээс харахад бидний судалгаанд хамрагдсан дөрвөн зохиогчийн бүтээлд “Халдвар” хэмээх сэдвийн хүрээнд кодлогдсон мэдээлэл хамгийн олон тохиолдож байгаа бөгөөд “Бусад эмгэг” сэдэвт агуулагдах тохиолдол удаалж “Бэртэл гэмтэл” гэсэн сэдэв хамгийн цөөн тохиолдолтой ажиглагдаж байна Түүнчлэн Цахар гэвшийн бүтээлд “Бэртэл гэмтэл” гэсэн сэдвийн хүрээнд ямар нэгэн мэдээлэл агуулагдаагүй нь нийт үр дүнд мэдэгдэхүйц нөлөөлөлтэй байгаа нь тодорхой юм.

Уг дөрвөн бүтээл дэх сэдвүүдийг нэгтгэн тооцвол нийт 60 тохиолдлоос халдвар 34 (56.66%), бэртэл гэмтэл 10 (16.66%), бусад эмгэгүүд 16 (26.66%) байна. Уг үр дүнгээс манай судалгааны хэрэглэгдэхүүнүүдэд агуулагдаж буй хятад эмнэлгийн мэдээллүүдийн олонх нь буюу 56.66% нь халдварын тохиолдолтой холбоо бүхий мэдээллүүд байна.



Зураг 2. Судалгаанд хамрагдсан бүтээлүүд дэх хятад анагаах ухааны мэдээлэлд сэдвүүдийн эзлэх хувь

Эдгээр бүтээлүүдэд халдвар гэсэн нийтлэг сэдвийн хүрээнд олон тооны халдварт өвчнүүд багтсан байх бөгөөд эдгээрийн зарим нь төвөд болон монгол онооосон нэр байхгүй тул зарим тохиолдолд шууд хятад нэрийг төвөд үсгээр галиглан бичсэн байна. Уг дөрвөн бүтээл дэх хятад эмнэлгийн холбогдол бүхий мэдээлэлд өвчин үүсэх нөхцөл, өвчний ангилал, өвчний шинж тэмдэг, оношилгоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, засал, идээ, явдал мөр, эдгэрсэн шинж, эмийн нэр, гоо сайхан, халдвар хамгаалал гэсэн арван нэгэн төрлийн кодоор түүвэрлэн ялгахад давхардсан тоогоор нийт 87 тохиолдол илэрсэн (Зураг 3).



Зураг 3. Кодоор ангилахад хамгийн олон давтамжтай илэрсэн код (зохиогч тус бүрээр)

Эдгээрийг ижил төстэй байдлаар эмчилгээ, өвчин, урьдчилан сэргийлэлт, бусад гэсэн сэдвүүдэд хураангуйлав (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Кодуудыг нэгтгэн сэдэвт хураангуйлсан байдал

	Сэдэв			
Код	Эмчилгээ	Өвчин	Урьдчилан сэргийлэлт	Бусад
	Эмчилгээ-57	Өвчний нөхцөл-4	Урьдчилан сэргийлэлт-4	Эмийн нэр-2
	Идээ, явдал мөр-2	Өвчний нэр-1	Халдвар хамгаалал-2	Гоо сайхан-1
	Засал-1	Өвчний ангилал-1		
		Өвчний шинж тэмдэг-10		
		Оношилгоо-1		
		Эдгэрсэн шинж-1		
Нийт	**60 (68.96%)**	**18 (20.68%)**	**6 (6.89%)**	**3 (3.44%)**

Кодуудыг сэдэвт хураангуйлсан хүснэгтээс үзэхэд хятад анагаах ухаанаас зээлдсэн эмчилгээ хятад эмнэлгээс орж ирсэн нийт мэдээлэл дотор томоохон байр буюу 68.96%-ийг эзэлж байна.

Хэлцэмж: Судалгааны үр дүнгээс харахад манай судалгааны хэрэглэгдэхүүнүүдэд агуулагдаж буй хятад эмнэлгийн мэдээллүүдийн олонх нь буюу 56.66% нь халдварын тохиолдолтой холбоо бүхий мэдээллүүд болох нь илэрсэн юм. Үүнээс үзвэл бидний судалгаанд сонгон авсан бүтээлүүдийг бичигдэж байх цаг үед халдварт өвчний асуудал хурцаар тавигдаж байсан нь илт ажиглагдаж байна. Ялангуяа цагаан цэцэг буюу бодоо болон шинээр тархсан тэмбүү өвчнийг эмчлэх эмчилгээний асуудал нэн хурцаар тавигдаж байсан нь энэ талаар асар их туршлага хуримтлуулсан хятад анагаах ухааны арга туршлагыг авч хэрэглэхэд хүргэсэн гэх таамаглалд хүргэж байна.

Уг дөрвөн бүтээл дэх хятад эмнэлгийн холбогдол бүхий мэдээлэлд кодуудыг сэдэвт хураангуйлж үзэхэд “Эмчилгээ” сэдэв нь хятад эмнэлгээс орж ирсэн нийт мэдээллийн ихэнх буюу 68.96%-ийг эзэлж байгаа нь олон зууны хөгжлийн явцад төвөд, монгол анагаах ухаан нь өвчин эмгэгийн шинж тэмдэг, ангилал зэргийн тухай өөрийн гэсэн цогц ойлголттой болсон тул энэ талын мэдээлэл авах нь төдийлөн онц чухал биш бөгөөд харин шинэ, үр дүнтэй эмчилгээний аргууд чухал байсан болохыг илэрхийлж байна. Үүн дотроос халдварт өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэлттэй холбоо бүхий мэдээллүүд чухал байрыг эзэлж байна. Түүнчлэн бидний судалгаанд хамрагдсан дөрвөн зохиолчийн бүтээлүүдэд цэцэг өвчний тарилга болон эмчилгээний асуудал нийт “Халдвар” гэсэн сэдвийн дотор томоохон хэсгийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Тиймээс тухайн үеийн монгол анагаах ухааны эрдэмтэд халдварт өвчний менежментийн асуудалд ямар учир шалтгааны улмаас голчлон анхаарах болсон учир шалтгааныг тодруулах нь чухал юм.

Хятад эмнэлгээс монгол эмнэлэгт орж ирсэн урьдчилан сэргийлэлт, эмчилгээний аргуудын талаар тухайлбал, цагаан цэцэг, тахал, чичрэг, тэмбүү зэрэг халдварт өвчнүүдийн үед монгол эмч нарын хэрэгжүүлж байсан эмчилгээ үйлчилгээний арга, ажиллагааны талаар судлаач Н.Батсайхан судалсан байна.[15] Хятад улсын судлаачдын зүгээс ч энэ чиглэлээр зарим нэгэн судалгааны ажлыг хийж байгаа бөгөөд судлаач Юү (2016) Хятад дахь бусад уламжлалт эмнэлгүүдийн

тухай бичсэн өгүүлэлдээ Монголчуудын хятадаас авсан арга, бэлгийн онол нь тэдний оношилгоо, эмчилгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Монголчууд энэ мэтээр хятад эмнэлгийн онол болон төвөд эмнэлгийн сургаалыг нийлэгжүүлэн авч өөрсдийн соёлд нийцсэн өвөрмөц анагаах ухааны тогтолцоог үүсгэж чадсан гэжээ.[16] Профессор Весна Монголчууд төвд анагаах ухааны зохиолуудыг судлахын зэрэгцээ хятад анагаах ухааны зүү төөнүүрийн холбогдол бүхий бүтээлүүдийг судалж байсныг 1601 онд зохиогдсон “Хатгах Төөнөх Тэргүүтэнг Хураасан Ном Дэвтэр” Зая бандид Намхайжамцын (1599–1662) шавь 1660 оны орчим орчуулсан жишээгээр өгүүлжээ.[17]

Монголын уламжлалт анагаах ухааны хөгжил нь Энэтхэг, Төвөд хийгээд Хятад зэрэг олон орны уламжлалт анагаах ухааны зохиолыг сурч судлахаас гадна өөрийн орны анагаах ухаантайгаа уялдуулан хөгжиж, зарим нэгээс санаа авч улмаар цаашид гүнзгийрэн хөгжиж байсантай адилаар манай монгол эрдэмтэд ч мөн энэ замаар уламжлалт анагаах ухааны эмчилгээний санаа болон туршлагыг өөрийнхөө сурч эзэмшсэн уламжлалт анагаах ухаантайгаа уялдуулан хөгжүүлж эмчилгээ үйлчилгээндээ хэрэглэж байсан байна.

Дүгнэлт:

1. Дээрх бүтээлүүдэд судалгаа хийхэд хятад эмнэлгийн мэдээллүүдийн 56.66% нь халдварын тохиолдолтой холбоо бүхий мэдээллүүд байна. Бодоо зэрэг халдварт өвчний үед хятад анагаах ухаанаас суралцсанаа монгол уламжлалт анагаах ухааны арга аргачлалтай ижилсүүлэн нэгтгэсэн нь өнөө үеийн нэгтгэмэл анагаах ухааны үйл явцыг нөхцөлдүүлсэн нэгэн томоохон нөлөөлөх хүчин зүйлийн илэрц байж болзошгүй.
2. Монгол эмч нар хятад эмнэлгийн онолын тайлбаруудаас илүүтэйгээр эмчилгээний практик үйл ажиллагааг сонгомлоор хэрэглэж байсан нь илүү тодорхой ажиглагдаж байна.

Ном зүй:

1. *Дагвацэрэн Б. Цог заль төгөлдөр “Дөрвөн үндэс”-ийн “Номлохуйн үндэс” тайлбар, тайлал: төрс зохиролт тогтолцоот нэгтгэмэл анагаах ухааны үндэс. Улаанбаатар: 2015. Жиком Пресс ХХК. х15*
2. *Janes, C. & C. Hilliard. Inventing tradition: Tibetan medicine in the postsocialist contexts of China and Mongolia, in L. Pordie (ed.), Tibetan Medicine in the Contemporary World: Global politics of medical knowledge and practice. Abingdon: Routledge. 2008.35–61.*
3. *Батсайхан, Н. Монгол Уламжлалт Анагаах Ухаан: Зарим Эх Сурвалжийн Нягтлан Шинжлэл. Улаанбаатар: Ном Хур. 2021. х.315*
4. *Болд, Ш., Амбага, М., Саранцэцэг Б., Болорцэцэг Ж. Монгол туургатны алдарт эмч, маарамба, мэргэдийн намтар. Улаанбаатар: Одсар системс. 1999. х.122-124*
5. *Жигмэд, Б. Монгол анагаах ухааны түүх болон эртний сурвалж бичгийн шинжилгээ. Улаанбаатар: Soyombo Printing. 2009.х.200*
6. *Сүмбэ Хамба Ишбалжир (1704-1788)-ийн 1752 онд бичсэн Рашааны Цагаан Шүүдэр (ཡེ་ཤེས་དཔལ་འབྱོར། 1994. གསོ་རིག་གསུང་རྩོམ་སྒྲིག་བསྡུས་ཚན་རིག། ཕྱོགས། མི་རིགས་དཔེ་སྐྲུན་ཁང་།)*
7. *Цахар Гэвш Лувсанчүлтэм (1740-1810)-ийн 1802 онд бард гарсан “Басамын Тосон Эм ба Таван Рашааны Дэвтээлэг Тэргүүтэнг Найруулах Арга”. (བློ་བཟང་ཚུལ་ཁྲིམ། 1802. འཕའ་གཅམ་སྐུན་མར་དང་འདྲད་ཆེ་ལུ་ལྷས་སོགས་བྱར་ཚུལ་བཞུགས་སོ། Модон барын хэвлэл. Цахар: Цагаан уулын сүм*
8. *Жамбалчойжиданзанпэрэнлэй. Анагаах Ухааны Шаштир Бүгдийн Шимийг Нэгэн Зүгт Хураасан Увдисын Эрдэнэ Гарахын Орон Хэмээх Оршвой. орчуулсан З.Ориг. Улаанбаатар: Очирпресс; 2018.*
9. *Ишданзанванжил. Рашаан Шим (Ишданзанванжилын Шүрэн Чимэгийн монгол төвөд хуучин бичмэл эхийн буулгамал). Бээжин: үндэстний хэвлэлийн хороо.2023.х*
10. *Батсайхан, Н., Сээсрэгдорж, С. Анагаах ухааны эх сурвалжийн судалгааны кодлон ангилах аргачлалуудыг ашиглах асуудалд. Нэгтгэмэл Анагаах Ухаан сэтгүүл. 2021;8(2):72-78.*
11. *Braun V, Clarke V. Using thematic analysis in psychology. Qual. Res. Psych. 2006; 3: 77–101.*
12. *Pope C, Ziebland S, Mays N. Analysing qualitative data. In: Pope C, Mays N (eds). Qualitative Research in Health Care (3rd edn). Oxford: Blackwell Publishing; 2006.*
13. *Elo S, Kyngäs H. The qualitative content analysis process. J. Adv. Nurs. 2008. 62: 107–115.*
14. *Qiu Peiran, ed., Chinese Medical Dictionary, Volume 2, Shanghai Science and Technology Press, August 2002, p. 927*
15. *Norov, Batsaikhan. 2019. Mongolian Buddhist Scholars’ Works on Infectious Diseases (Late 17th Century to the Beginning of the 20th Century). Religions 10(4): 229.*
16. *Yu E, Amri H. 2016. China’s Other Medical Systems: Recognizing Uyghur, Tibetan, and Mongolian Traditional Medicines. Global Advances in Health and Medicine. 5(1):79-86.*
17. *Wallace, Vesna A. 2012. “The method-and-wisdom model of the medical body in traditional Mongolian medicine.” Arc: The Journal of the School of Religious Studies 40: 25-46.*

Some influences of Chinese medical methods on the Mongolian traditional sourcebooks

Tsetsenbaatar G[1], Chimedragchaa Ch[2], Batsaikhan N[1,3], Alimaa T[1,3]

[1]International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Institute of Traditional Medicine and Technology of Mongolia
[3]Institute of Mongolian Traditional Medicine, MNUMS
E-mail: alimaa.t@mnums.edu.mn, Tel: +976-99040103

Background: Medicines with unique healing methods and European medical treatments and services, which have been used around the world to this day, are now being used in a combined form in the healthcare services of many countries, and the possibility of integrating them is a widely discussed issue among researchers. It is noteworthy that no independent research has yet been published that has analyzed in detail how the influence of Chinese and other medical schools has been reflected in the development of Traditional Mongolian medicine. It is considered important to analyze this issue individually, in each direction, to clarify the historical process of how Traditional Mongolian medicine was formed today.
Aim: Conduct research within specific codes in the works of Mongolian doctors to identify the presence of Chinese medical data, knowledge, and information.
Materials and Methods: The research was conducted using a qualitative research method based on historical and source books. Our study employed content and thematic analysis, utilizing coding and the identification of recurring patterns in the source text.
Results: The results of the coding study show that most of the data used from Chinese meicines falls under the code “infection”. In Sumbe Khamba Ishbaljir’s sourcebook, 42.8% of the information was coded as infection, in Tsakhar Gevsh Luvsanchultemi’s sourcebook 50%, in Mindol Khutagt Jambalchoyjidanzanperenle’s sourcebook 47.05%, and in Ishdanzanvanjil’s “Shuren Chimeg” 87.5% was coded as infection. After that, when the information included in the code “injury” is classified by each sourcebooks, 33.3% is found in Ishbaljir’s sourcebook, 0% in Luvsanchultem, 24% in Mindol Khutagt Jambalchoyjidanzanperenley, and 6.25% in Ishdanzanvanjil, which ranks second among all codes.
Conclusions:

1. According to the research results, 56.66% of the Chinese medical information in the above works is related to infection cases.
2. The integration of Chinese medicine learning with Traditional Mongolian medicine methods during epidemics such as “Bodoo” may be a major influencing factor that has shaped the current integrative medicine process.

Keywords: Traditional medicine, Source studies, Content analysis, Thematic analysis